

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР



НИЙЛҮҮЛЭГЧ:

МЕД МОНГОЛ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ХАЛИУН



“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв”-д иммуногематологийн шинжилгээний гель аргын оношлуур нийлүүлэх шууд гэрээ.

2016 оны 3 сарын 25

Улаанбаатар хот

Нэг талаас **Цус сэлбэлт судлалын үндэсний төв** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **Мед монгол ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 03 сарын 25-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2 Захиалагч нь “R-Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төвд цусны хүүдий, оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 2016 он 03” дугаартай тендерийн **“Имуногематологийн шинжилгээний гель аргын оношлуур”-ын 2-р багцын** (цаашид “бараа” гэх) нийт **26,598,990** (хорин зургаан сая таван зуун ерэн найман мянга есөн зуун ерэн) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг нийт **26,598,990** төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.4 Нийлүүлэгч нь барааг 2016 оны 04 дугаар сарын 15-наас 2017 оны 3 дугаар сарын 25-ны дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- 1.5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 1.5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 1.5.2 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
- 1.5.3 Тендер ба үнийн хуваарь;
- 1.5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 1.5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 1.5.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 1.5.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 1.6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 1.7 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.8 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Захиалагч нь 1.4-т дурдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 20 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.
 - 2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн нийт үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх алдангийг хэтрүүлсэн хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.
 - 2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах үүрэгтэй.
-

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

- 3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.
- 3.2. Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.
- 3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.
- 3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хоногийн 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

Дөрөв. Хүчинтэй хугацаа

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

Тав. Бусад зүйл

- 5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
- 5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцөх боломжгүй болсон тохиолдолд ХАҮТ-ын дэргэдэх арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- Уг гэрээ нь монгол хэл дээр 3 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний
Төвийн Ерөнхий нягтлан бодогч Д.Гүнжээ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны
өргөн чөлөө-13, С.Зоригийн гудамж

Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

УЛААНБААТАР ХОТ
Мед монгол ХХК-ийн

Менеджер Б.Оюунгэрэл

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Элчингийн гудамж

14-1, 1-р давхар, 102 тоот

Утас: 70154448 , Факс: 70154449

Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны үнийн хуваарь

огноо: 2016.03.25

ХТШ-ын дугаар : 2016 он 03

ИММУНОГЕМАТОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЕЛЬ АРГЫН ОНОШЛУУРЫН БАГЦ №2

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын буюу ерөнхий нэршил	Гарал үүсэл	Шардлагайн хүн тун	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
	1	2	3	4	5	6	7	8
1	ID – Card “Liss/Coombs” Шууд болон шууд бус кумбсын урвал тодорхойлох карт	Indirect and direct antiglobulin test	BioRad	15	Gel card	48 карт	704785	10,571,770
2	ID – Card “DAT IgG dilution” анти Д –ийн титр тодорхойлох карт	Determination of IgG	BioRad	6	Gel card	12 карт	325636,67	1,953,820
3	ID – Diluent 2 шингэлэгч уусмал	Modified LISS for red cell suspensions	BioRad	2 фл	Шингэн	1*500мл	902330	1,804,660
4	Эсрэг бие илрүүлэх оношлуур эс	ID-Diacell 1-2-3	BioRad	12	Шингэн	1 цомогтоо 3*10 мл	294177	3,530,120
5	Эсрэг бие дүйн тодорхойлох оношлуур эс	ID – Diapanel	BioRad	12	Шингэн	цомогтоо11 *4мл	728218,33	8,738,620
	Нийт дүн							26,598,990

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ: ИММУНОГЕМАТОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЕЛЬ АРГЫН ОНОШЛУУРЫН БАГЦ №2

№	Бүтээгдхүүний нэр	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Шардагдаж буй хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь	
						4.15	8.15
1	ID – Card “Liss/Coombs” Шууд болон шууд бус кумбсын урвал тодорхойлох карт	Indirect and direct antiglobulin test	Gel card	48 карт	15 хайрцаг	7	8
2	ID – Card “DAT IgG dilution” анти Д – ийн титр тодорхойлох карт	Determination of IgG	Gel card	12 карт	6 хайрцаг	4	2
3	ID – Diluent 1 шингэлэгч уусмал	Modified LISS for red cell suspensions	шингэн оношлуур	1*500мл	2 фл	1	1
4	Эсрэг бие илрүүлэх оношлуур эс	ID-Diacell 1-2-3	Оношлуур	1 цомогтоо 3*10 мл	12 цомог	Сар бүр 1 цомгийг нийлүүлэн	
5	Эсрэг бие дүйн тодорхойлох оношлуур эс	ID – Diapanel	Оношлуур	1 цомогтоо 11*4мл	12 цомог	Сар бүр 1 цомгийг нийлүүлэнэ	